

Агуулга

ОРШИЛ	3
1.1. Ордын байршил, физик газар зүй	3
1.2. Дэд бүтэц	4
1.3. Байгаль орчны төлөв байдлын суурь нөхцөл	5
II. 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОВЧ	7
2.1. 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө.	7
2.3. Тухайн жилд ашиглагдах тоног төхөөрөмж.....	8
III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	9
3.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	9
3.2. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	10
3.3. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл....	10
3.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	10
IV. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	11
4.1. Газар ашиглалт хөрсний элэгдэл, эвдрэлийг багасгах.....	11
4.2. Гадаргын болон гүнийн усны хамгаалал.....	12
4.3. Ургамал амьтны аймгийг хамгаалах	12
V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	13
5.2. Газар, хөрсний элэгдэл, эвдрэлд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арга хэмжээ.	14
5.3. Усан орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	14
5.4. Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээ.....	15
VI. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
VII. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
VIII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
IX. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
XI. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
XII. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
XIII. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	20
XIV. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	21

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв 23

Хүснэгт

Хүснэгт - 1. MV-010206 тоот тусгай зөвшөөрлийн цэгийн солбилцол 4
Хүснэгт - 2. MV-010207 тоот тусгай зөвшөөрлийн цэгийн солбилцол 4
Хүснэгт - 3. Бутлах цехийн тоног төхөөрөмж 8
Хүснэгт - 4. ZL-50 утгуурт ачигчийн техникийн үзүүлэлт 9
Хүснэгт - 5. Автосамосвалын техникийн үзүүлэлт 9
Хүснэгт - 6. Нийт гүний усны хэрэглээ 10
Хүснэгт - 7. Агаарын чанарын нөлөөлөл..... 13
Хүснэгт - 8. Хөрсний эвдрэлийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ. 14
Хүснэгт - 9. Усан орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ. 14
Хүснэгт - 10. Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх нөлөөлөлийг бууруулах арга хэмжээ. 15
Хүснэгт - 11. Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө. 15
Хүснэгт - 12. Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө..... 17
Хүснэгт - 13. Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөө..... 17
Хүснэгт - 14. Түүх соёлын өвийг хамгаалах ажлын төлөвлөгөө..... 18
Хүснэгт -15. Хог хаягдлын менежментээр хэрэгжүүлэх ажил..... 18
Хүснэгт -16. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 19

Хавсралт

Хавсралт 1. Батлагдсан үйлдвэрийн төлөвлөгөөний нүүр.....23
Хавсралт 2. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөв маягт 1.1.....24
Хавсралт 3. Уурхайн ус хангамж маягт 6.2.....25
Хавсралт 4. Байгаль орчны нөхөн сэргээлт маягт 10.....26
Хавсралт 5. Уул уурхайн төслийн БОМТ-ний хяналтын хуудалс.....30
Хавсралт 6. Улсын бүртгэлийн гэрчилгээ.....41
Хавсралт 7. Байгаль орчны лавлагаа.....43
Хавсралт 8. Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл.....47
Хавсралт 9. ТЭЗҮ хүлээн авсан тухай тушаал дүгнэлт.....57
Хавсралт 10. Байр зүйн зураг.....61


ОРШИЛ

Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших Баргилт-Овоо төмрийн хүдрийн ордыг “Лут чулуу” ХХК нь MV-010206, MV-010207, тоот тусгай зөвшөөрлийн дагуу эзэмшдэг. 2005 онд ашиглалт явуулж эхэлсэн бөгөөд 2014 онд гүйцээх хайгуулын ажлыг хийсэн. Ордын хэмжээнд явуулсан гүйцээх хайгуулын ажлаар бодитоор (В) болон боломжтой (С) зэргийн нөөц 7212.36 мян.тн-оор тооцоолсон. Тус хайгуулын ажлын үр дүнд тулгуурлан орд ашиглах ТЭЗҮ-д ордыг цаашид далд уурхайн аргаар ашиглахаар тусгасан бөгөөд 21 жилийн хугацаанд ашиглана гэж тооцоолжээ.

ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.


1.1.Ордын байршил, физик газар зүй

Баргилт Овоо төмрийн хүдрийн орд нь засаг захиргааны хувьд Хэнтий аймгийн Дархан сумын нутагт байрладаг. Улаанбаатар хотоос зүүн урагш 320км, Дархан сумаас баруун урагш 35 км, Бор-Өндөр сумаас баруун хойш 12 км тус тус зайтай.



Зураг - 1. Ордын байршил

“Лут чулуу” ХХК –ий эзэмшлийн талбай нь “Баргилт овоо-1” нэртэй MV-010206, MV-010207 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайнуудад хамаарна. “Лут чулуу” ХХК 2013-2014 онд гүйцээх хайгуулын ажлыг өөрийн хөрөнгөөр хийж нийт 802.7 сая.төг зарцуулсан бөгөөд ордын нөөцийг В+С зэрэглэлээр 6,9 сая.тн төмрийн хүдрийн нөөцийг бүртгүүлсэн.



Зураг - 2. Тусгай зөвшөөрлийн талбайнуудын байрлал

Хүснэгт - 1. MV-010206 тоот тусгай зөвшөөрлийн цэгийн солбилцол

№	Уртраг	Өргөрөг
1	109°18'31.73"	46°19'34.65"
2	109°17'44.73"	46°19'34.65"
3	109°17'44.73"	46°20'1.65"
4	109°18' 31.73"	46°20'1.65"

Хүснэгт - 2. MV-010207 тоот тусгай зөвшөөрлийн цэгийн солбилцол

№	Уртраг	Өргөрөг
1	109°17'19.73"	46°20'14.42"
2	109°17'50.17"	46°20'14.42"
3	109°17'50.17"	46°19'34.65"
4	109°17' 44.73"	46°19'34.65"
5	109°17' 44.73"	46°20'10.65"
6	109°17'19.73"	46°20'10.65"

1.2. Дэд бүтэц

Хэнтий аймаг нь Зүүн бүсийн бусад аймгуудыг бодвол дэд бүтцийн хөгжлөөр харьцангуй сайн байна. Сүүлийн 3 жилд бүх төрлийн эх үүсвэрээс нийт 49,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд дэд бүтцийн салбарт 70 хувийг нь зарцуулжээ. Хэнтий аймаг нь хатуу хучилттай авто замаар холбогдсон бөгөөд ихэнх сумдуудтай шороон замаар холбогдоно.

Өндөрхаан хот нь 35 кв-ын цахилгаан дамжуулах шугамаар төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон. Цаашдаа Өндөрхаан – Баруун-Уртын 110 квт, Өндөрхаан - Чойбалсангийн 220 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж зүүн бүсийн

аймгуудыг төвийн бүстэй эрчим хүчний нэгдсэн сүлжээгээр холбохоор “Эрчим хүчний нэгдсэн сүлжээ” хөтөлбөрт тусгагджээ.

Бор-Өндөрийн район нь манай улсын уул уурхайн үйлдвэрлэл хөгжсөн нэг гол район юм. 2008 онд “Тун-Синь ХХК” нь өөрийн хөрөнгөөр Бор-Өндөрийн УБҮ-ийн дэргэдэх 110/35/6 кВ дэд станцаас Баргилт Овоогийн төмрийн хүдрийн ордын уурхай хүртэл нийт 15 км 35 кВ-н өндөр хүчдэлийн шугам татаж, ордын дэргэд 35/0.4 кВ-н дэд станц байгуулан, 24 цагийн цахилгаанаар хангагдаад байна. Мөн Баргилт Овоогийн уурхай Бор-Өндөр суман дахь төмөр замын ачиж буулгах талбай хүртлэх 9 км сайжруулсан шороон замтай бөгөөд Бор-Өндөр сум нь босоо тэнхлэгийн төв төмөр замтай холбогдсон, ажиллах хүчин тэр дотроо мэргэжилтэй ажиллах хүчний хангалттай нөөцтэй, уулын үйлдвэрийн нэгэн томоохон район учир энэ орчимд шинээр уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлэх таатай нөхцлийг бүрдүүлж байна.

Дархан сум Бор-Өндөрөөс 35 кв-ын цахилгаан дамжуулах шугамаар төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон. Улаанбаатар-Чойр, Замын Үүдийн мянганы хатуу хучилттай зам нь нутгийн баруун талаар 100 км-ын зайтай өнгөрдөг.

1.3. Байгаль орчны төлөв байдлын суурь нөхцөл

Уур амьсгал, ус зүй

Тус сумын нутаг эрс тэс эх газрын уур амьсгалтай бөгөөд агаар нь хуурайвтар, хур тунадас бага унадаг, өвөл нь хүйтэн, жилийн ба хоногийн температурын хэлбэлзэл их байдаг. Агаарын температурын сарын дундаж нь бүх нутгаар 8-13 градус байдаг ба олон жилийн дунджаар 1,5 градусаар дулаан байна. Жилд дунджаар 200 орчим мм тунадас унадаг. Нутгийн ноёлох салхи баруун хойноосоо ихэвчлэн салхилдаг ба хамгийн их салхи шуургатай үе нь 3, 4, 5-р сар юм.

Гадаргын усан хангамжаар муу, ихэвчлэн газрын гүний усыг ашигладаг. Сумын хойд талаар баруунаас зүүн тийш өөрийн аймгийн Дэлгэрхаан сумтай 23 км-ээр хиллэн урсаж өнгөрдөг Хэрлэн гол урсана. Сумын нутаг дэвсгэрт Дотуур булаг, Шавартай, Бор хужир, Боонгын булаг, Дэвтээрийн булаг зэрэг тачир устай 31 булаг шанд байдгаас жил ирэх тутам ширгэн усгүй болсоор байна. Цайдам, Нарийн, Бүрд, Аман хужирын, Шар нуур, Хужирын хонхор зэрэг сумын хэмжээнд 17 нуур тойром байдгаас одоогийн байдлаар 9 нуур тойрмоос бусад нь ширгэн усгүй болсон байна. Мөн сумын хэмжээнд гүний, инженерийн, энгийн зэрэг 110 гаруй худаг уст цэг байдаг.

Хөрс, ургамал зүй

Сумын нутаг дэвсгэрт тархсан хөрсийг шинж чанар газар зүйн байршил хөрс үүсгэгч нөхцөлөөр нь долгиорхог тал, хээрийн ба өргөн хөндийн хөрс мөн голын хөндийн, нугын хээршсэн хөрс, уулархаг, уулын хөрс, хээрийн элсэрхэг, хүрэн хөрс гэж хуваана. Долгиорхог хээр талын ба өргөн хөндийн хөрс зонхилох хувийг эзэлнэ.

Ургамалын хувьд уул хээрт: Цахилдаг, алаг өвст, хиаг-хялганат, бужмаг, хонгорзул, улалж, бут бударгана, харгана, халгай, буурцагт өвсний төрөл зонхилно.

Тал хээрт: Үетэн хялганат, хазаар өвс, хиаг-хялганат, шарилж, лууль, дэрс болон амт чанар, шимт сайтай үетэн, буурцагт, алаг өвсний төрлийн ургамал зонхилно. Мөн гол, булаг, нуур тойрмын хөвөөгөөр хиаг, хазаар өвс, салхин ерхөг, дэрс, харгана, адамсын агь, хэрс зэрэг ургамал ургадаг ба сумын урд говирхог талаараа таана, мангир, хөмүүл, ерхөг, үетэн хялганат, алаг өвс, жижиг бутан үетэн, ботуульт ургамал зонхилон ургадаг байна.

Ан амьтан

Дархан сум нь амьтны аймгийн төрлөөр баян нутаг билээ. Агнуурын ан амьтан: Чоно, үнэг, хярс, бор туулай, дорго, хүрнэ, мануул, цагаан зээр, тарвага зэрэг ан амьтан элэг тааралдана. Ховор ан амьтан: Дархан ууланд 1980-аад оны эхээр буга согоо, аргаль угалз

нутагшиж ирсэн ба ховор ан амьтны төрөлд орох гозоорой зурам нь мөн ууланд элбэг тааралдана.

Аргаль угалз нь сүүлийн арваад жилд Дархан уулаас Эрэгнэг уул, Ноён Баян уул, Адагийн уулуудад тархан нутагшиж тоо толгой нь өсөж байна. Одоогийн байдлаар буга 20 гаруй болж, аргаль хонины тоо толгой 200-д хүрчээ.

Жигүүртэн шувуу: Махчин шувууд: Энэ төрлийн шувуудаас Дархан сумын нутаг дэвсгэрт бүх төрлийн бүргэд, шилийн сар, идлэг шонхор, начин шонхор, зээрд шонхор, тас, элээ, шар шувуу зэрэг шувуудаас гадна ховор шувуу болох ёл нь Дархан ууланд үзэгдэх болсон байна.

Давхарга зүй

Дунд Мезопротерозой. Ангилагдаагүй метаморф чулуулаг (MP₂)

Дунд мезопротерозой настай ангилагдаагүй хурдасыг нь өмнөх судлаачид протерозой насанд хамруулж ирсэн байдаг. Дунд мезопротерозой настай метаморф чулуулаг нь *доод-дунд перм Бүрэнцогт* болон *хожуу триас-түрүү юра. Бор-Өндөр интрузив бүрдэлүүдийн* боржингоор түрэгдэн хэрчигдэж блоклогдон хуваагдсан ба баруун хойноос зүүн чиглэлд сунасан байдалтай Баргилт Овоогийн төмрийн ордын хүдрийн биетүүдийн агуулагч хурдас юм.

Доод-дунд перм. Бүрэнцогт формац (P1-2 bc)

Судалгааны талбай, түүний орчмын нутаг нь хожуу палеозойн эх газрын вулканоген бүрдлүүдийн байршлын ерөнхий бүдүүвчид тэмдэглэснийг ажиглахад өмнөд хэрлэнгийн вулканоген бүсийн Хойд Говийн хотгорын ар хэсэгт байрлах бөгөөд (*В.В.Ярмолюк, 1983*) хөрш талбайн хэмжээнд илрэх вулканоген-терриген хурдас нь уламжлагдан ирсэн ангиллаар пермийн системийн доод-дунд серид хамаарагдах ба вулканоген бүсийн энэ хэсэгт Бүрэнцогт формац хэмээн ангилагддаг хурдсын нэг хэсэг болно.

Гүний чулуулаг

Судалгааны талбайд түрүү-дунд Перм Бүрэн цогтын бүрдэл болон түүнийн зүсэн гарсан хожуу Триас- түрүү Юрагийн настай Бор өндөрийн гүний чулуулаг бүрдэл нь ашиглалтын талбайн урд болон зүүн хойд хэсгээр тархсан байдаг.

Түрүү-дунд Перм гүний чулуулгийн бүрдэл нь скарн, түүний хүдэржилтэнд нөлөөлөх нэгэн хүчин зүйл нь болсон гэж өмнөх судлаачид бичсэн байдаг. Дүүргийн хэмжээнд янз бүрийн насны гүний чулуулаг өргөн тарсан боловч Баргилт Овоогийн төмрийн ордын ойролцоо хамгийн их тархсан гүний чулуулгийг насны хувьд дараах байдлаар ангилан бичлээ. Үүнд:

- 1. Бүрэн цогт диорит-монзонит-шүлтлэгдүү боржингийн бүрдэл /γP_{1-2b}/*
- 2. Бор-өндөр аляскит-лекоборжингийн бүрдэл /γT_{3-J1b}/*

Геоморфологи

Талбайн гадаргуугийн тогтоцыг дэлхийн дотоод хүчний үйлчлэлээр үүссэн тектоник-элэгдлийн, гадаад хүчний үйлчлэлээр үүссэн идэгдэл-хуримтлалын гэсэн 2 төрөлд хуваана, Тектоник-элэгдлийн гадаргууд уулархаг нутаг, идэгдэл-хуримтлалын гадаргууд уул хоорондын хотгор, эртний ба орчин үеийн хөндийнүүд орно.

Тектоник-элэгдлийн гадаргуу: Энэ төрлийн гадаргууг дотор нь үнэмлэхүй өндөр, хэрчигдэлтийн зэргээр нь дунд өндөртэй уулсын хүчтэй хэрчигдэлтэй гадаргуу, нам уулсын муу хэрчигдэлтэй гадаргуу, налуувтар хажуутай гүвээ, толгорхог гадаргуу гэж 3-н дэд төрөлд хуваана.

Ордын гидрогеологи

Баргилт Овоогийн төмрийн хүдрийн ордын гидрогеологийн нөхцөлийг тусгайлан судлах зорилгоор ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд тогтоогдсон ан цавын ус агуулагч

хэсэгт 2008-2009 онуудад гидрогеологийн 3 ш цооног өрөмдөж 2 ш худаг гаргасан боловч тус худгууд нь үйлдвэрийн усан хангамжийг шийдвэрлэх усны ундрага бүхий усны нөөц болж чадхааргүй ан цав хагарлын хэсэгт орших ба хур бороо багатай, зуны улиралд усны ундрага багасан, усны төвшин нилээд буудаг байна.

Тус 2ш худгийн ус нь гидрокарбонат төрлийн кальци-магнигаар баялаг, хатуулаг өндөртэй учир уурхайн ундны хэрэгцээнд тэнцэхгүй учир ажилчдын ахуйн хэрэгцээ болон зам талбай услах зэргээр ашиглаж байна. Ордын гүйцээх хайгуулын явцад хайгуулын өрөмдлөгийн 19 ш цооногуудаас усны ундрагатай усны үе илрээгүй.


II. 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОВЧ

2.1. 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө.

2023 онд манай уурхай нь далд аргаар олборлох бүтээн байгуулалтын ажил явагдах бөгөөд 300 мян.тн хүдэр олборлохоор төлөвлөгөөнд тусгагдаад байгаа бөгөөд. Нийт 79500 гаруй тууш метр малталтын ажил хийгдэхээр төлөвлөгдсөн байгаа.

2.2. Бутлах цехийн технологийн схем болон горим

Төмрийн түүхий хүдэр нийлүүлэх Монголросцветмет ХХК-аас 500мм-н ширхэглэл хүртэлх төмрийн хүдрийг хүлээн авах талбайд буулгана. Анхдагч хүдрийг 1-р шатны бутлуураар бутлан 150мм-ийн ширхэглэлтэй хүдэр гаргана. 2-р шатны бутлуураар бутлан 80мм-н ширхэглэлтэй гарсан хүдрийг дахин 3-р шатны бутлуураар бутлан бутлагдсан хүдрийг хяналтын шигшүүрээр шигшинэ. Хяналтын шигшүүрээс -10+0мм, -40+10, -80+40 мм-ийн ширхэглэлтэй 3 бүтээгдэхүүн гарна. Шигшүүрийн доорх -10+0 мм-ийн ширхэглэлтэй хүдрийг туузан конвейерээр тээвэрлэн бутлагдсан хүдрийн задгай талбай руу ачааллана. Мөн шигшүүрийн доорх -40+10 мм-ийн ширхэглэлтэй бүтээгдэхүүнийг 4-р шатны бутлуур руу оруулан бутлагдсан хүдрийг мөн бутлагдсан хүдрийн задгай талбай руу тээвэрлэнэ. Шигшүүрийн дээрх -80+40мм-ийн ширхэглэлтэй бүтээгдэхүүнийг эргэлтийн бүтээгдэхүүн болгон 3-р шатны бутлуур руу дахин ачааллана.



Зураг-3. Бутлах үйлдвэрийн технологийн схем

2.3. Тухайн жилд ашиглагдах тоног төхөөрөмж

Баяжуулах үйлдвэрт


Хүснэгт - 3. Бутлах цехийн тоног төхөөрөмж

Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Суурилагдсан тоо	Байнга ажиллах тоо	Нэгж чадал [кВт]
Хацарт бутлуур	PE900 x 1200	1	1	110
Конусан бутлуур	ZMJ900A	1	1	160
Конусан бутлуур	P1750	1	1	160
Шигшүүр	2SZZ2060	2	2	22
Алхат бутлуур	PC800X600	2	2	55
Тэжээгүүр	GZD600X1800	3	3	2.2
Туузан дамжуурга	2DD50-10	12	12	8.5
Нийт		22	22	517.7

Хүдэр тээвэрлэлтэнд


Хүснэгт - 4. ZL-50 утгуурт ачигчийн техникийн үзүүлэлт

Үзүүлэлт	ZL-50
Утгуурын багтаамж, м ³	3
Мөчлөгийн хугацаа сек	28
Ачилт хийх хамгийн их өндөр, мм	4350
Ачилт хийх өндөр, мм	3065
Их биеийн өргөн, мм	3000
Их биеийн урт, мм	7430
Их биеийн өндөр, мм	3310
Арын эргэлтийн радиус, мм	3610
Хөдөлгүүрийн төрөл	WD10G22E11
Масс, кг	18700
Хөдөлгүүрийн чадал, м.х	215



Хүснэгт - 5. Автосамосвалын техникийн үзүүлэлт

Техникийн үзүүлэлтүүд	North Benz 2527K
Даац	25
Машины өөрийн жин	12.4
Хөдөлгүүрийн төрөл	WP10.270
Тэвшний багтаамж	17 м ³
Хөдөлгүүрийн дээд чадал	270 Ps/rpm
Хөдөлгүүрийн дээд эргэлт	1100 N.m
Дугуйн тэнхлэг хоорондын зай	3800+1450
Дугуйн гадаргуу	12.00-20/11.00-20
Дээд хурд	≥85
Хөтлөгчийн хэлбэр	6X4
Тэвшний хэмжээ	5200*2300*1500



Ш. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уурхайд ашиглагдаж буй машин механизмаас ялгарах бохирдуулагч бодисууд болон уулын ажил, хөрсний овоолго, зам зэргээс үүсэх тоос нь агаарыг бохирдуулахад гол нөлөө үзүүлнэ.

Тээврийн хэрэгслийн хөдөлгүүр дэх түлшний дугуу шаталтаас агаарт ялгарах хортой хийн зонхилох хувийг азотын нэгдлүүд эзэлдэг. Энэ бохирдуулагч бодисууд нь агаарын чанарыг муутгаж хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.

Хүдэр бутлах ажиллагаанаас тоос үүснэ. Тоос тоосонцор нь хүндийн хүчний нөлөөгөөр газрын гадаргад буун хөрс болон ургамлын бүрхэвчид сөрөг нөлөө үзүүлнэ.

3.2. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2022 оны үйл ажиллагаагаар бутлуур болон далд уурхайн босоо болон налуу ам орчмын газрын гадарга элэгдэлд орох улмаар тоос шороо босох сөрөг нөлөөлөл үүсэхээр байна. Уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал өөрчлөгдөж, хөрсөн бүрхэвч доройтно. Хүдэр болон хөрс тээвэрлэх зэрэг үйл ажиллагаанаас шалтгаалан сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсч тоосжилт үүсгэх, газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдож болзошгүй.

3.3. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2022 онд уурхайн технологийн хэрэгцээ болон усалгааны хэрэгцээ зэрэгт 2500 м³ ус хэрэглэхээр байна. Унд ахуйн усны хэрэглээг Бор-Өндөр сумаас зөөврөөр хэрэглэнэ. Уурхай дээрх гүний ус нь унд ахуй хэрэглээний стандарт норм-д тохирохгүй.

Хүснэгт - 6. Нийт гүний усны хэрэглээ

Д/д	Усны зардал	Хэмжих нэгж	2022 он
1	Байгаль орчин хамгаалах, усалгаа	м ³	500
2	Ахуйн болон бусад усны хэрэгцээ	м ³	1000
3	Усалгааны хэрэгцээ	м ³	500
4	Далд уурхайн бэлтгэл малталт	м ³	500
5	Нийт жилийн гүний усны хэрэгцээ	м³	2500

Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдох эрсдэлтэй.

3.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Төслийн хүрээнд бутлах, шигших цех, тосгон, уурхайн дотоод зам бусад барилга байгууламжийн улмаас үүссэн хөрсний эвдрэлийг дагаж ургамлан нөмрөгийн талхлагдал, доройтол үүснэ. Энэхүү эвдрэлээр ургамлан нөмрөг ихээхэн хэмжээгээр хохирч, ургах орон зай нь багасахаас гадна ургамлын төрөл зүйл цөөрч бүрмөсөн устах магадлалтай.

Уурхайн үйл ажиллагаа явагдаж буй талбайд хөхтөн шувуу, жижиг мэрэгч амьтад амьдардаг болохыг тогтоосон. Төслийн үйл ажиллагаанаас ургамлын нөмрөгт өөрчлөлт гарч байгаа бөгөөд түүнтэй уялдан амьтдын амьдрах орчин доройтно. Идэш тэжээл нь хомсдож, тархац нь багасна.

IV. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Уурхайн олборлолтын болон баяжуулах үйл ажиллагаа явагдах үед газар орчны эвдрэл тодорхой хэмжээгээр гардаг. Уулын ажил явуулах талбайд тоног төхөөрөмж байрлуулах, суурилуулах байгууламжуудын байршлыг зөв сонгох, үйлдвэр зохион байгуулалтын ажлыг зохих журмын дагуу хийснээр тухайн газар орчныг эвдрэлээс тодорхой хэмжээгээр хамгаалах болно.

Тухайн жилд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг тодорхой түвшинд хийнэ. 2022 оны үйлдвэрлэл болон олборлолтын явцад доорхи арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үйл ажиллагааг газар эдэлбэрийн хуулийн дагуу аймаг, сум, багийн засаг даргын захирамжаар зөвшөөрөгдсөн талбайд зөвхөн зураг төсөлд тусгагдсан хил хязгаарын дотор явуулна.
- Уурхайн гадаад болон дотоод тээвэрлэлтэнд зориулагдсан замыг зөвхөн нэг маршрутаар хийх.
- Уурхайд ажиллах машин, техникүүдийг шатахуунаар цэнэглэх, урсгал засварыг хийхдээ зөвхөн тусгайлан зассан талбайд хийх.
- Ургамлын хар шороон хөрсийг тогтоогдсон хэмжээний зузаантайгаар эвдрэлд орох талбайгаас хуулан авч, тусгай овоолгод байрлуулах.

4.1. Газар ашиглалт хөрсний элэгдэл, эвдрэлийг багасгах

Төслийн хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийн үнэлгээнээс үзэхэд дээрхи сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Энэхүү арга хэмжээг төлөвлөхдөө “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль”-ийн дагуу хөрс хамгаалах нийтлэг арга хэмжээг үндэслэн боловсруулав.

- Бутлагдсан овоолгыг салхины зонхилох чиглэлийн дор байрлуулж ус, салхины нөлөөгөөр хүдрийн овоолгоос нарийн ширхэгтэй элс, чулуулаг зөөгдөж хөрсөн б үрхэвчид эвдрэл гэмтэл үүсгэхгүй байх.
- Хөрсний бохирдол, эвдрэлээс хамгаалахын тулд дараахи үйл ажиллагааг төлөвлөн гүйцэтгэнэ. Үүнд:
- Ашиглалтын явцад үүсэх овоолгуудыг төлөвлөлтийн дагуу тогтворжуулалт, хэлбэржүүлэлтийн ажлыг хийж, түүний гүйцэтгэлд хяналт тавих
- Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх
- Уурхайн технологийн дотоодын болон гадаад тээвэрлэлт, үйлчилгээний зориулалтын тээврийн хэрэгсэлийн зорчих сайжруулсан зам, талбайг иж бүрэн тэмдэгжүүлэн, тээврийн хэрэгсэл, уулын машин механизмын хөдөлгөөнийг заасан маршрутаар хязгаарлах,
- Суурины горитог дахь чөлөөт талбайг нутгийн болон ижил төст ургамлаар тарималжуулан, ногоон байгууламж байгуулах

4.2. Гадаргын болон гүнийн усны хамгаалал

- Дахин ашиглагдаж буй усыг зөвхөн үйлдвэрлэлд ашиглах төдий биш мөн уурхайн талбай дахь тоосжилтыг дарах, талбайг чийгшүүлэхэд ашиглах, уурхайн шүүрлийн усыг цэвэршүүлэн зам услах зэрэг ажил ашиглах, үерийн хамгаалалтын барилга байгууламжид усны угаагдал, гулдрилын эвдрэл зэргээс хамгаалах арга хэмжээг тусгах шаардлагатай.
- Үйлдвэр үйлчилгээний газарт хамаарах талбайд мод бут сөөг тарьж зүлэгжүүлэх нь үерийн их урсацын хэмжээг багасгах төдийгүй усаар зөөгдөх хатуу бодисын хэмжээг бууруулахад зайлшгүй хэрэгтэй.
- Хэрэглээнээс гадуурх ус ашиглалт болон хаягдал усыг чанарын шаардлагад нийцүүлэх.
- Бохир ус агуулах нүхийг гүний ус хөрсийг бохирдуулахгүй байх үүднээс газрын хөрсөнд нэвчхээргүй материалаар доторлон байнгын хяналт тавих
- Ундны усны эх үүсвэрт тогтмол хими-бактерологийн шинжилгээ хийлгэж шаардлага хангаж байгаа эсэхийг тогтмол хянана.
- Үйлдвэрлэлийн болон ахуйн хаягдал усаар гадаргын болон газрын доорхи усны нөөцийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах
- Шингэн хаягдал хөрс болон гүний усыг бохирдуулж байгаа эсэхийг шалгаж биологийн болон химийн шинжилгээ хийлгэнэ.

4.3. Ургамал амьтны аймгийг хамгаалах

- Техникийн нөхөн сэргээлт хийсэн ашиглагдсан талбайд богино хугацаанд биологийн нөхөн сэргээлт хийх.
- Хүн болон машин техникийг хөдөлгөөнийг тогтсон маршрутын дагуу явуулах.
- Хэт хуурайшилттай, салхи ихтэй нөхцөлд газрыг чийглэж услаж байх.
- Тоосны ялгаралтыг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгахын тулд байнгын хяналттай ажиллах.
- Байгаль орчны үнэлгээний ба нөхөн сэргээлт явуулж буй байгууллага, хүрээлэнтэй хамтран ажиллаж тоосжилт хэмждэг багаж төхөөрөмжтэй болж, тоосжилтонд хяналт тавих.
- Талбай дахь ховор ургамал, бэлчээр тэжээлийн үнэт ургамлуудыг хамгаалах
- Төслийн ажилчид нь ан, амьтан буй газарт анхааралтай хандан үйл ажиллагаагаа явуулах ба тэдгээрийн амьдарлын нөнхцөлийг алдагдуулахгүй байх.
- Тээврийн хэрэгслийн хурданд хязгаарлалт хийх.
- Ажлын талбайн гадна шөнийн цагаар хурц, тод гэрэл ба дуу, шуугиан гаргахгүй байх
- Төслийн үйл ажиллагаанаас бий болсон ухаш, нүх суваг шуудууг тойруулан хашаа барьж тэмдэгжүүлж мал амьтан ороож гэмтэж бэртэхээс хамгаалах.
- Хог хаягдлын менежмент боловруулан, түүнийхээ дагуу ажиллах.
- Ганц төслийн талбай гэлтгүй төслийн талбайн ойр орчимд хогийн цэг, бие засах газрыг байрлуулах.
- Уурхайн үйл ажиллагаа явуулж буй газрын ойролцоо ан амьтан агнахгүй байх, хамгаалах мэдээлэл, сурталчилгаа хийх, анхааруулсан зурагт хуудас байрлуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх.

V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт - 7. Агаарын чанарын нөлөөлөл

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт	Зардал төг
1	Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тос, маслыг 250 мот/цаг тутамд сольж байна.	Механик инженер	250 мот/цаг тутамд тээврийн хэрэгслүүдийг тос, маслыг солиж байна.	2,000,000
2	Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг услаж байх.	Уурхайн дарга	7 хоногт 2-3 удаа, хур тунадас ихтэй үед усалгаа хийгдэхгүй	3,000,000
3	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө.	Уурхайн дарга	Үйлдвэрлэлийн ажилд хамрагдах 6 тээврийн хэрэгсэл, байна.	60000
	Нийт			5,060,000

5.2.Газар, хөрсний элэгдэл, эвдрэлд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арга хэмжээ

Хүснэгт - 8. Хөрсний эвдрэлийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	Компанийн захирал	Гэрээ, төлбөр төлсөн баримт байна.
2	ШТС-н бүрэн бүтэн байдлыг хянах тогтмол үзлэг хийх, мөн ШТС-с цэнэглэлт хийх тоолонд асгаралтаас сэргийлсэн журам боловсруулах, газар болон хөрсөнд түлш бензин асгаруулахгүй байх сургалт семинар явуулах.	ХАБЭА-н ажилтан	Сургалтын агуулга, хөтөлбөрийг уурхайн даргаар батлуулах, сургалт семинар явуулах.
3	Өмнөх онуудад хийсэн техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд олон наст ургамал тарих	Уурхайн дарга	Фото зураг баримтжуулалт байна. 500 000
	Нийт зардал		500 000 төг

5.3. Усан орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтанд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Хүснэгт - 9. Усан орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Уурхайд ашиглагдаж буй худаг орчмоор цэвэрлэгээ хийх газрын гадаргаас гүний худагруу бохирдуулахгүй байх арга хэмжээ авах.	ХАБЭА-н ажилтан	Фото зураг баримтжуулалт байна. Улирал тутам
2	Ахуйн бохир усыг зайлуулах цооног байгуулах ашиглах	Уурхайн захирал.	Фото зураг баримтжуулалт байна. 2 000 000
3	Усны хомсдол болон ус зарцуулалтын талаар ажилчидад сургалт явуулах, усны хэрэглээг ариг гамтай ашиглах талаар сургалт семинар явуулах	ХАБЭА-н ажилтан	Сургалтын агуулга, хөтөлбөрийг уурхайн даргаар батлуулсан байна. Фото зураг баримтжуулалт.
	Нийт зардал		2 500 000

5.4. Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээ

Хүснэгт - 10. Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ.

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Олон салаа зам гаргахгүй байх.	Уурхайн дарга	Тогтмол нэг замаар үйл ажиллагаагаа явуулах
2	Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байрлуулна.	Уурхайн дарга	Багаж хэрэгсэл нийт 500000 төгрөг болно. Ажил эхлэх үед
3	Мод тарих зөвлөмж болон ургамал тариалах, ургамлын үр хадгалах зэрэг зөвлөмжийг ажилчидад сургалт явуулна	Уурхайн дарга, ХАБЭА-н ажилтан	Сургалтын агуулга, хөтөлбөрийг уурхайн даргаар батлуулсан байна. Фото зураг баримтжуулалт байна.
	Нийт		500 000

VI. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Баргилт овоо төмрийн хүдрийн ордыг ашиглах төслийн уурхайн хаалтын ажлыг MNS6296:2011, далд уурхайн хаалт стандарт болон улсын мэргэжлийн хяналтын газрын 309-р тушаалын дагуу батлагдсан Уурхайг түр болон бүр мөсөн хаах журам-г баримталж гүйцэтгэх бөгөөд ашиглалтын жил бүр нөхөн сэргээх ажлыг үе шат дараагаар хийнэ. Тухайн жилд байгаль орчны техникийн болон биологийн нөхөн сэргээлт тодорхой хэмжээнд хийгдэнэ.

Хүснэгт - 11. Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө.

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Мод, сөөг бутлаг ургамал тарих боломжтой газар мод тарих.	Уурхайн дарга	Модны суулгац худалдан авах, 500 000 200ш 5 болон 9-р сард газар
	Нийт		500 000



VII. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэнийн үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн зорилго болно. Дүйцүүлэн хамгаалах газрыг тогтоохдоо нөлөөлөлд өртсөн газартай ойр байх, экологийн хувьд дүйцэхүйц байх, дүйцүүлэн хамгаалах хугацааг нөлөөлөл үргэлжлэх хугацаатай харьцуулж тогтоох, урт хугацааны хамгааллыг хангах, зарчимуудыг баримтлах шаардлагатай. Үүнээс гадна дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ нь шинээр хамгаалалт бий болгосон, эсвэл биологийн олон янз байдлын хэвийн нөхцөлд илүү эерэг нөлөөлөл үзүүлсэн байх шалгуур тавигдана.

Манай уурхайн хувьд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд орон нутгийн удирдлага, байгаль орчны мэргэжилтэн болон улсын байцаагч нартай харилцан тохирон төсөл хэрэгжиж буй талбайтай ойр эвдрэлд орсон талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөлөө.

Хүснэгт - 12. Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө.

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Тухайн нутаг орны хэмжээнд хувиараа чулуу олборлогч иргэд газрыг сэндийчиж нөхөн сэргээлт хийлгүй орхиж байгаа бөгөөд энэ нь байгаль экологид сөрөг нөлөө үзүүлж байгаа учир техникийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай байгаа газар 2 гад техникийн нөхөн сэргээлт хийнэ	Уурхайн дарга	Тухайн эвдрэлд орсон газрын өмнөх болон техникийн нөхөн сэргээлт хийсэн фото зураг баримтжуулалт байна. 2 сая

VIII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нүүлгэн шилжүүлэх, нутгийн иргэдийн эрүүл мэнд, эрх ашиг, амьжиргаа, соёлын өвийг хамгаалах болон бусад төлөвлөлттэй хэрхэн уялдсан байдал зэрэг нь нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний шалгуур үзүүлэлт болох бөгөөд, төсөл хэрэгжих явцад, төслийн талбайтай ойр орших малчид, нутгийн иргэдийн санал гомдол ирсэн тохиолдолд, санал гомдлыг хүлээн авч харилцан тохиролцон шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх бөгөөд тодорхой хэмжээний зардал мөнгөтэй холбоотой асуудлыг шийдвэрлэнэ.

Хүснэгт - 13. Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөө

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Төслийн талбайтай ойр орших нутгийн иргэд малчидаас ирсэн гомдол, саналыг хүлээн авч шийдвэрлэнэ.	Уурхайн дарга	Уурхайн удирдлагад хандсан албан хүсэлт, саналт гомдол байна, баримтжуулна.
	Нийт		1 000 000

IX. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн хувьд гүний чиглэлтэй бөгөөд далд уурхайн малталтын явцад түүх соёлын дурсгалт зүйл болон түүхийн ховор олдвор олдсон тохиолдолд нэн яаралтай олборлолтын ажлыг зогсоож холбогдох албан тушаалтан болон газарт мэдэгдэж шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт - 14. Түүх соёлын өвийг хамгаалах ажлын төлөвлөгөө.

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Олборлолтын явцад гарч ирсэн олдвор, түүхийн дурсгалт зүйл гарч ирсэн тохиолдолд шаардлагатай ажлыг авч хэрэгжүүлнэ.	Гүний уурхайн ээлжийн мастер, маркшейдер	Ээлжийн мастерын мэдэгдэл байна, түүхийн дурсгалт олдвор олдсон тохиолдолд фото зураг баримтжуулалт болон холбогдох газрын дүгнэлт байна.
	Нийт		Ашиглалтын зардалд орно.

XI. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежментээр хэрэгжүүлэх боломжтой ажлууд:

- Уурхайн хотхоны гэрүүдийг утаагүй түлшээр галлаж байх
- Хуванцар сав, төмөр лааз, ялгаж цуглуулаад тушааж байх. Жилд дунджаар 1000 ширхэг хуванцар сав гарч байгаа ба байгальд хаягдах сөрөг нөлөөлөл нь нэг ширхэг хуванцар сав байгальд шингэлгүй 200- 500 жил болно гээд бодоод үзэхэд байгальд учруулж байгаа нөлөө нь маш их юм.
- Шил нь байгальд хэзээ ч устахгүй материал учраас варены шилийг аль болох хаяхгүй байх хэрэгтэй. Варены шилийг ногоо даршилж хийн дахин ашиглаж болно.
- Харин хаягдал ногооны хальс болон хоолны үлдэгдлийг ашиглан хөрсийг ялзмагжуулахад ашиглаж болно.
- Үйлдвэрт тос арчих зориулалтаар хуучин хувцас авч ашиглах нь эдийн засгийн болоод экологийн хувьд үр дүнтэй арга юм.
- Бүх ажилтан албан тушаалтнууд нь ахуйн хог хаягдлаа дахин ашиглагдах боломжтой хогнуудыг ялган хаяж занших хэрэгтэй.

Хүснэгт -15. Хог хаягдлын менежментээр хэрэгжүүлэх ажил

Д.д	Хог хаягдлын талаар хийгдэх ажлууд	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлнэ.		Гэрээ байна. Зардал нь үйл ажиллагааны зардалд орно. Ажил эхлэхэд
2	Хог хаягдлын төлбөрөө төлнө.		Төлбөр төлсөн баримт байна. Зардал нь үйл ажиллагааны зардалд орно.
3	3 тасалгаат хогийн савыг байршуусан.		Хогийг ангилж хаях.
4	Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр, гал тогоонд хортон шавьжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх		Улаанбаатар хотын гоц халдвартын төвөөр хийлгэх. Зардал нь 500 000 төгрөг
5	Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх, задлах бодис худалдаж авах зардал		5 болон 10 сард 2 удаа 680 000 төгрөг
	Нийт		1 180 000

ХИ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга болон хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны мэргэжилтэнгүүд хариуцан ажиллана. Доорх ажлуудыг компанийн захирал тушаал гаргаж баталгаажуулна.

Хүснэгт -16. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, төг	Хариуцагч
1.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах.	5, 10 сард	200000төг	Уурхайн дарга
2	Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгаалалын хувцас хамгаалах хэрэгсэлээр бүрэн хангах	Ажил эхлэх үед	Үйл ажиллагааны зардалд орсон	Уурхайн дарга

ХШ. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, талуудад тайлагнах хуваарь

Хугацаа	Олон нийтэд тайлагнах, танилцуулах ажлын жагсаалт	Зохион байгуулах хүний албан тушаал
2022 оны 9-р сард	холбогдох мэргэжилтэнгүүдийг газар дээр нь танилцуулна.	Байгаль орчны ажилтан, Уурхайн дарга болон компанийн захирал Зардал нь үйл ажиллагааны зардалд орно.
Ирэх оны 12 сарын 1-нд багтаан	Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангаа боловсруулж байгаль орчны албанд хүргүүлнэ.	

XIV. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээний дээж	Хяналт шинжилгээний үзүүлэлт	Хяналт шинжилгээний хэлбэр. зардал	Хяналт шинжилгээний явуулах хугацаа	Хяналт шинжилгээний явуулах байршил	Хяналт шинжилгээ хийх багаж. холбогдох стандарт
1	Агаар	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж. NO ₂ . SO ₂ CO -ын агууламж. Хүнд металл тодорхойлох Агаар орчны бохирдол агаар дахь цацраг. дуу чимээ	Агаарын шинжилгээний 2 цэгт жилд 2 удаа хэмжилт хийлгэнэ. Нэг удаагийн шинжилгээний хөлс 100 000 төг. 2 цэг*1 удаа*100 000= 200 000 төг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2011 оны 10 сарын 10-ны өдрийн А-342 дугаар тушаалын хавсралтаар тооцов.	6 сард	Уурхай, уурхайн зам	Агаарын тухай хууль. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль. Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010. Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007
2	Ус	Усны ерөнхий химийн шинжилгээ. бактерлогийн шинжилгээ (рН. ЕС. TDS. нийт шүлтлэг. хатуулгын хэмжээ. рН. цахилгаан дамжуулах чанар. Cl. SO ₄ . NO ₂ . NO ₃ . CO ₃ . HCO ₃) Ахуйн хаягдал усны ерөнхий химийн шинжилгээ. бактерлогийн шинжилгээ (рН. ЕС. TDS. нийт шүлтлэг. хатуулгын хэмжээ. рН. цахилгаан дамжуулах	Хаягдал бохир усны цэг болон ундны усны 2 цэгт жилд 3 удаа дээжлэлт авч шинжилгээнд шинжлүүлнэ. Усны ерөнхий химийн шинжилгээ нэгжийн үнэ 20000 төг. Хими бактериологийн бүрэн шинжилгээний үнэ 141700 төг 2цэг*1 удаа*161700 төг =323400 төг	9 сард	Худаг, Хаягдал бохир уснаас 2	Усны тухай хууль. Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2008. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010. Ундны усны. эрүүл ахуйн шаардлага. чанар. аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005. Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил. цэвэрлэгээний технологи. түвшинд тавих үндсэн шаардлага MNS

		чанар)	*УСУГ итгэмжлэгдсэн лабораторийн үнэ			4288:1995. Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журам Байгаль орчны сайд. Дэд бүтцийн хөгжлийн сайд. Эрүүл мэндийн сайдын 1995 оны 167/335/А/171 тоот тушаалын 2-р хавсралт.
3	Хөрс	Хөрсний агрохими. нийт азот. хөдөлгөөнт фосфор. солилцох кали. карбонат. Хүнд металл(Cr. Pb. Cd. Ni. Zn). бактери	Хөрсний хяналт шинжилгээний 2 цэгт жилд 3 удаа Хөрсний механик бүрэлдэхүүн. ялзмаг 20000төг1 Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 45.0 мян.төг 2 2 цэг* 1 удаа* 65000төг = 130 000төг Газарзүйн хүрээлэнгийн хөрсний төв лаборатори 2-Эс жи Эс лаб ХХК үнэ авав.	9 сард	Уурхайн шимт хөрсний овоолго ахуйн бохир усны хаягдал орчимд	- MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр. төрөл - MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох - MNS2305-94 Дээж авах. савлах. тээвэрлэх. хадгалах журам - MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх
4	Нийт		1 000 000 төг томилолтын зардал багтсан.			-

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв

Д.д	Зардлын утга	Нийт зардал, сая.төг
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	5 060 000
2	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	500 000
3	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	2 500 000
4	Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх нөлөөлөлийг бууруулах арга хэмжээний зардал	500 000
5	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	500 000
6	Дүйцүүлэн хамгаалах ажлын зардал	10 000 000
7	Нүүлгэн шилжүүлэх ажлын зардал	1 000 000
8	Хог хаягдлын менежментийн зардал	1 180 000
9	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	200 000
	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1 000 000
	2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	22 440 000

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **22 440 000** төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө болгож 11 220 000 төгрөгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9,15 дахь заалтанд зааснаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулна.